

Бүрэн Дунд Боловсролын Гэрчилгээний (HSC) минимум стандарт

Эцэг эх болон асран хамгаалагчдад зориулсан мэдээлэл

Хүндэт эцэг эх, асран хамгаалагч танаа

NSW мужийн Боловсролын Стандарт Хариуцсан Захиргаанаас (NSW Education Standards Authority (NESA)) Бүрэн Дунд Боловсролын Гэрчилгээнд (HSC) минимум стандартын бодлогыг нэвтрүүлсэн ба энэ нь NSW мужийн сурагчид Бүрэн Дунд Боловсролын Гэрчилгээ авахын тулд бичгийн болон тооны минимум стандарт бүхий чадварыг батлан харуулах хэрэгтэй гэсэн үг юм.

Сурагчид уншлага, бичлэг болон тоо гэсэн гурван чадвараар HSC минимум стандартын тест шалгалт өгнө. Онлайн тест бүр 45 минут үргэлжлэх ба дараах бүтэцтэй байх болно. Үүнд:

- Уншлагын олон сонголттой тест;
- Тооны олон сонголттой тест; мөн
- Бичгэн эсвэл зурган өгөгдөл бүхий бичгийн шалгалт (500 хүртэлх үгтэй)

Сурагчид HSC минимум стандартыг хангахын тулд гурван чадвар дээрээ 3 эсвэл 4-р түвшинд хүрэх шаардлагатай. Энэ нь тухайн стандартыг хангасан сурагчид өдөр тутмын ажил, амьдрал болон үргэлжлүүлэн суралцахад шаардагдах үндсэн суурь ур чадварыг эзэмшсэн гэсэн үг юм.

Сурагчид 10-12-р ангид суралцах хугацаандаа энэхүү онлайн тестүүдийг жил бүр олон удаа өгөх боломжтой. Шалгалтыг дахин өгөх тохиолдолд тодорхой хугацаагаар хүлээх шаардлагатай байдаг.

Сурагчдыг HSC минимум стандартыг хангахад нь сургуулийн зүгээс дэмжиж ажиллах болно. Давтлагын тестүүд сургууль дээрээс авах мөн NESA вэб хуудас дээрээс жишээ асуултууд олж авах боломжтой:

<https://educationstandards.nsw.edu.au/wps/portal/nesa/11-12/hsc/hsc-minimum-standard/online-tests>

Хэрвээ та дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл сургуультай холбогдоно уу.

Хэрвээ таны хүүхэд нэмэлт хэрэгцээтэй бөгөөд HSC минимум стандартын шалгалтанд нэмэлт хангамж авах шаардлага хангасан гэж үзвэл доор дурдсан сургуулийн холбогдох ажилтантай утсаар холбогдоно уу.

Сургуулийн холбогдох ажилтны нэр

Сургуулийн холбогдох ажилтны утасны дугаар

Хүндэтгэсэн

Захирал

Сургуулийн нэр

Утсан Орчуулгын Үйлчилгээ

Хэрвээ танд сургуультай холбогдох орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн хэл дээрх орчуулагчийг хүсээрэй. Операторт залгахыг хүссэн дугаараа хэлэхэд оператор таны яриаг орчуулах орчуулагчийг шугамд холбож өгөх болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.